



104

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/178 дугаар захирамж, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн А/178 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 1, 3, 4, 5 дугаар хороодод 2021 онд санхүүжүүлэх 13, 11 дүгээр байрны фасадны, 30а, 2а дугаар байрны дээврийн завсарын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хороо (Б.Ганзориг)-нд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.


4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/21 дүгээр тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.ГАНЗОРИГ

(Барилга захиалагчийн хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Б.БАТМӨНХ

(НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн Дэд бүтэц, тохижилт, худалдаа үйлчилгээний салбарын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.САЙНБАЯР

(Захиргааны хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Г.ШООВДОР

(Баянгол дүүрэг 15 дугаар хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Х.ХОНГОРЗУЛ

(Барилга захиалагчийн хэлтсийн Барилгын хяналтын инженер)